



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/247

Мандлговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Онгоцны буудлын зүүн хойд талд) байршилтай Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар (9033548)-ын цэцэрлэгт хүрээлэн байгуулах зориулалттай 300000 м.кв (30 га) газраас 69000 м.кв (6,9 га) газрыг Биеийн тамир спортын хороо (9033653)-нд цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбайн зориулалтаар 11 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр эрхийг шилжүүлж, үлдсэн 231000 м.кв (23.1 га) газрыг Засаг даргын тамгын газар (9033548)-т зориулалтын дагуу 11 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх хоёр байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/754 дугаар захирамж мөн газар эзэмших 000435682 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200715

